

2021 хичээлийн жилийн гадаад оюутан өвлийн амралтаар гадаадруу гарах болон буцан орж ирэх(тусгаарлалт) холбоотой чухал зүйлийн хөтөч

Уг хөтөч нь 22-1 семестрт манай сургуульд суралцах гадаад оюутан дунд өвлийн амралтаар гадаадруу гарах(төлөвлөж буй) гадаад оюутны гадаадруу гарах болон буцан ирэх(тусгаарлалт) холбоотой чухал зүйлийг мэдэгдэж буй хөтөч юм. Гадаадруу гарахын өмнө болон Солонгос улсад буцан орж ирэх үед шаардлагатай шат дамжлагын талаар заавал гүйцэт сайн ойлгохыг хүсэх бөгөөд, корона-19 холбоотой бүх бүртгэл болон тусгаарлалт нь өөрийн биеээр хариуцан явуулах ёстой гэдгийг мэдэгдэж байна.

■ Хамрах хүрээ : 22-1 семестрт манай сургуульд суралцах оюутан дундаас өвлийн амралтын хугацаанд гадаадруу гарах(төлөвлөж буй) хүн

[Гадаадруу гарахыг хязгаарлах хүн]

- 22-1 семестрийн бакалаврт шинэ·шилжин орох хүсэлт гаргагч нь баримт бичгийн шалгалт болон оршин суух эрхийн өөрчлөлтийн улмаас гадаадруу гарах боломжгүй
- Виз(VISA)-ий хугацаа 22 оны 1~2 сард дуусах оюутан нь сургуулиар дамжуулан 'виз сунгалт' хийх шаардлагатай тул гадаадруу гарах боломжгүй

■ Өвлийн амралтаар гадаадруу гарахтай холбоотой хөтөч

1. Сургуулиас амралтын хугацаанд нутаг буцалгүй Солонгост үлдэхийг зөвлөж байна.
2. Зайлшгүй шалтгаанаар гадаадруу гарах шаардлагатай тохиолдолд, доорх 2 зүйлд бүртгүүлэн зөвшөөрөл авж байж гадаадруу гарах боломжтой юм.

① Сургуулийн гадаадруу гарах бүртгэл

- Бүртгэлийн хугацаа: 11.15(Даваа) ~ 11.18(Пүрэв) 18 цаг хүртэл (хугацаанд заавал судалгаанд оролцох)
- Бүртгүүлэх арга: Доорх линкээр орон хугацаанд гадаадруу гарах бүртгэл <https://forms.gle/truC3cmqJz3fGjsz8>
- Анхаарах зүйл: Заавал заасан хугацаанд гадаадруу гарах хүсэлтийн бүртгэл хийх шаардлагатай бөгөөд, гадаадруу гарах эсэх нь өөрчлөгдсөн оюутан нь тэр даруй оффист мэдэгдэх шаардлагатай

② Цагаачлалын алба 'буцан нэвтрэн орох зөвшөөрөл' бүртгэл

- Урьдчилан сургуульд бүртгэл хийлгэсэн оюутан л бүртгүүлэх
- Бүртгүүлэх арга: Онлайн hikorea эсвэл цагаачлалын албанд очин бүртгүүлэх
- Цагаачлалын албаны буцан нэвтрэн орох зөвшөөрөл авсны дараа, 'буцан нэвтрэн орох зөвшөөрлийн баталгаа'-г оффист заавал хураалгах шаардлагатай
- (Анхаарах зүйл)
 - Буцан нэвтрэн орох зөвшөөрөл авалгүй хилээр гарсан тохиолдолд, гадаад иргэний үнэмлэх(VISA) устан буцан нэвтрэх орох боломжгүй болно
 - Буцан нэвтрэн орох зөвшөөрөл авсны дараа онгоцны тийзээ өөрчилвөл өмнө бүртгүүлсэн буцан нэвтрэн орох зөвшөөрөл цуцлагдана. Тусад нь шалгах шаардлагатай

3. Гадаадруу гарахын өмнө болон Солонгост дахин нэвтрэн орох үед 'PCR сөрөг хариуны баталгааны хуудас'-г хураалгах шаардлагатай юм.
4. Урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр гадаадруу гарах эсвэл буцан орж ирвэл гадаад оюутны виз цуцлагдах болон зөвшөөрөл-буцан ирэх, тэтгэлэг олголт зэрэгт асуудал үүсэж болно.
5. Буцан ирэх оюутан нь Солонгосын онгоцны буудал дотор хилээр гарах явцдаа гадаад иргэний үнэмлэхээ хураалгаж болохгүй.
 - ※ Буцан орж ирэх хүн нь гадаад иргэний үнэмлэхээ хураалгавал, гадаад иргэний үнэмлэх(VISA) устах болно.
6. Гадаадруу гарахын өмнө хичээлд асуудал үүсэхгүй байхаар урьдчилан хичээлийн төлөвлөгөө(хичээлийн оролцоо, хичээл сонголт зэрэг)г нарийн гаргахыг хүсье.
7. 22-1 семестрийн хичээл орох аргын талаар хараахан шийдэгдсэн зүйл байхгүй бөгөөд, корона-19 чиг хандлагыг тусгасан ангиар орох хичээлийг ихэсгэхээр төлөвлөж байна. (шаардлагатай тохиолдолд өөрийн тэнхимээс лавлах)
8. 22-1 семестрийн дотуур байрны бүртгэл болон орохтой холбоотой мэдэгдлийг дараа дахин мэдэгдэх бөгөөд, төлөвлөж буй орох өдрөөс хойш дотуур байранд орох боломжгүй.
9. Гадаадруу гарсны дараа Солонгост буцан орж ирэх үед корона-19 холбоотой бүх бүртгэл (тосолт, PCR шинжилгээ, тусгаарлалт зэрэг)-н зардлыг өөрийн биеээр хариуцан хийх шаардлагатай юм.

■ Солонгост буцан орж ирэх болон тусгаарлалттай холбоотой хөтөч

Тусгаарлалттай холбоотой үе шат болон явц нь эрх бүхий хотын захиргааны хорио цээрийн дэглэмийг дагаж мөрдөн хувиараа явуулах

<p>Буцан ирэхийн өмнө</p>	<p>Гадаадаас орж ирж буй бүх гадаад иргэн нь 'Корона-19 сөрөг хариуны баталгааны хуудас(солонгос эсвэл англи хэл дээр)'-тай байх ёстой (※Байхгүй тохиолдолд хилээр нэвтрүүлэхээс татгалзаж байна)</p> <ul style="list-style-type: none"> - Онгоц хөөрөх цагт тулгуурлан 72 цагийн дотор авсанг л хүлээн зөвшөөрөнө - PCR сөрөг хариуны хуудсан дээр өөрийн гадаад паспортны хугацаа мөн төрсөн он сар өдөр, гадаад паспортон дээрх англи нэр зэрэг орсон байх ёстой - PCR сөрөг хариуны хуудас шинжилгээ/авахтай холбоотой нарийн зүйлийг хилээр орж ирэхийн өмнө заавал орон нутгийн элчин сайдын яамнаас лавлах - Орж ирсний дараа тусгаарлалтын байр захиалга болон онгоцны буудлаас тосох машин зэргийг заавал захиалга хийх шаардлагатай
<p>Хилээр орж ирэх үед</p>	<ol style="list-style-type: none"> 1. PCR сөрөг хариуны хуудас хураалгах 2. Онгоцны буудлын хорио цээрийн дэглэм, өөрийгөө тусгаарлах аюулгүй байдлын хамгаалалтын апп суулгах 3. Хилээр нэвтрэх шалгалт/ачаа тээшээ авсны дараа гарах хаалгаар гарж ирэх 4. Тусдаа тээврийн хэрэгсэл(тосолтын такси, дуудлагын машин, асран хамгаалагч зэрэг) ашиглан явах (ирсний дараа нийтийн тээвэр ашиглах боломжгүй) <p>※ Хорио цээрийн үе шатанд шинж тэмдэгтэй хүний ангилалд орвол, онгоцны буудал дотор PCR шинжилгээ болон нөхцөл байдлаас хамааран онгоцны буудлын зочид буудал руу хүлээгчээр ангилдана(зардал гарна). Халдвар авсан нь тогтоогдвол эмнэлэг эсвэл эмчилгээний төв рүү хүргэгдэнэ</p>
<p>Хилээр орж ирсний дараа (тусгаарлалт)</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хилээр орж ирсэн тухайн өдрөө PCR шинжилгээ өгөх 2. 10 хоног тусгаарлалт хийх (Хилээр орж ирсэн өдрөөс эхлэ 10 хоног тусгаарлалт) 3. Өдөрт 1 удаа биеийн байдлаа ажиглах 4. Тусгаарлалт дуусахаас 1 хоногийн өмнө PCR нэмэлт шинжилгээ (Тусгаарлалтын 9дөх хоног дээр нэмэлт шинжилгээ өгөх) <p>※ Солонгос улсад вакцин хийлгэн буцан хилээр орж ирж буй тохиолдолд, шаардлага хангагдсан тохиолдолд үед тусгаарлалтаас чөлөөлөгдөх боломжтой - нарийн зүйлийг тусад нь мэдэгдэнэ</p>
<p>Анхаарах зүйл</p>	<ul style="list-style-type: none"> ✓ Гадаадаас орж ирж буй хүн нь тусгаарлалтын хугацаанд гадуур гарах болон нийтийн тээвэр ашиглах боломжгүй бөгөөд, заавал тогтоосон тээврийн хэрэгсэл ашиглан эрүүл мэндийн төв(PCR шинжилгээ) болон тусгаарлалтын байр руу явах ✓ Ирсэн тухайн өдрөө онгоцны буудлаас гадагшаа гарахын тулд асран хамгаалагч эсвэл мэргэжлийн тосолтын байгуулгын жолооч онгоцны буудал дээр ирэх шаардлагатай ✓ Хилээр орж ирсний дараа хамаарах эрүүл мэндийн төвд очин PCR шинжилгээ нийт 2 удаа(ирсэн өдөр, тусгаарлалтаас гарахаас 1 хоногийн өмнө) заавал өгөх <ul style="list-style-type: none"> - 1р шат: Ирсэн өдрөө тогтоосон тээврийн хэрэгслийг ашиглан эрүүл мэндийн төвд тэр даруй очин корона шинжилгээ өгөх - 2р шат: Тусгаарлалт дуусахаас 1 хоногийн өмнө адил аргаар эрүүл мэнд төвд очин нэмэлт шинжилгээ өгөх <ul style="list-style-type: none"> ▶ Явах арга нь заавал тогтоосон тээврийн хэрэгсэл(хувийн машин эсвэл хорио цээрийн такси, дуудлагын машин)-г ашиглах шаардлагатай ✓ Тусгаарлалт хийх боломжтой газар нь бие даасан орон зай(1 өрөө байр зэрэг)-нд ганцаараа байх боломжтой орчин байх шаардлагатай ✓ Зочид буудал, мотел, зочны байр, 2-с олон хүн цуг ашигладаг олон нийтийн байранд тусгаарлалт хийх боломжгүй ✓ Тусгаарлалтын хугацаанд тусгаарлалтын байрнаас гадагш дур мэдэн гарах эсвэл зугтвал, холбогдох хуулийн дагуу албадан нутаг буцаах зэрэг арга хэмжээ авна

■ Санал болгож буй буцан ирэх огноо: Тусгаарлалтын хугацаа болон дотуур байранд орох өдөр зэргийг харгалзан багадаа 14 хоногийн өмнө орж ирэхийг зөвлөж байна

■ 22-1 семестр болон хаврын улирлын хичээл эхлэх өдөр: 2022 оны 2 сарын 28 өдөр(Даваа)

Хилээр орж ирэх шат дамжлага болон хорио цээрийн арга Солонгосын төрийн бодлогоос хамааран өөрчлөгдөж болно гэдгийг мэдэгдэж байна.